

**ХОВД ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ШИЙДВЭР, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

/2017 оны 01 сарын 04-ний өдрийн хурал/

- Докторант багш, ажилтан нарт Судалгааны аргазүйн талаар 1/10, 3/10-нд сургалт зохион байгуулна. Оюутны амралтаар Улаанбаатар явах докторант нарт цалинтай чөлөө, замын зардал олгох, Багш нар ажлын төлөвлөгөө гаргаж явахыг Ч.Лхагвасүрэн, Бүрэлдэхүүний сургуулийн захирлуудад даалгав.
- Зарим багш нарын цалинтай, цалингүй чөлөө, унааны зардал, хүссэн өргөдлийг дараах байдлаар шийдвэрлэв.
- Ус алдалтын хохирол тогтоох тухай Ажлын хэсэг нэгдсэн дүгнэлтээ дараагийн хурлаар оруулж ирэхийг эдийн засагч Д.Түвшинбатад үүрэг болгов.
- МХТТ-ийн багш Т.Буяндэлгэрт мэргэжил дээшлүүлэхэд нь зориулж цалинтай чөлөө, замын зардал олгохоор шийдвэрлэв.
- Гэрээний биелэлтийг эцэслэн гаргаж яаралтай хүргүүлэхийг Б.Болормаад /ХШҮ-ний мэргэжилтэн/ даалгав.
- 2016 оны захирлын үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг эцэслэж боловсруулах тухай Б.Болормаа /ХШҮ-ний мэргэжилтэн/-д үүрэг болгов.
- 2016 оны үйл ажиллагааны тайлан боловсруулах Б.Батмөнх /ЭЗХХ хариуцсан дэд захирал/-д хариуцуулав
- 2017 оны төсвийн төсөл боловсруулан Удирдах зөвлөлийн хуралд оруулахад бэлтгэхийг Дэд захирал, Бүрэлдэхүүний сургуулийн захирлууд, Санхүүгийн албанд даалгав.
- Дотоод аудитын дүгнэлтийн мөрөөр тавигдсан алдаа дутагдлыг яаж арилгах талаар дараагийн хурлаар оруулж ирэх Д.Өрнөхдэлгэр /ССБТЗ эрхэлсэн дэд захирал/, Б.Дэлгэрцэцэг /Санхүүгийн албаны дарга/ нарт даалгав.
- 2016 оны жилийн эцсийн орлого, зарлагын баланс гаргахыг Б.Дэлгэрцэцэг /Санхүүгийн албаны дарга/-г даалгав.
- Байгалийн шинжлэл, технологийн сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч З.Бурмаа, Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч С.Гаура, Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Сувданцэцэг нарын жинхлэх тайланг дараагийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулав.

**Захиргааны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын чиглэлийг гаргасан:**

**Б.Болормаа /Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн/  
Ховд хот, 2017.01.07**